**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН**
**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр Дугаар А/01 Чойр

Байгууллагын орон тоо, бүтэц,

цалин тогтоох тухай

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоол, Аймгийн засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/150 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 онд байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, орон тоог 1 дүгээр хавсралтаар, ажилтан, албан хаагчдын цалинг 2 дугаар хавсралтуудаар тус тус батлсугай.

2. Байгууллагын үйл ажиллагааг батлагдсан орон тоо, бүтцийн хүрээнд зохион байгуулан, албан хаагчдын цалин хөлсийг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолыг үндэслэн олгохыг Төсвийн мэргэжилтэн ба нягтлан бодогч /Н.Одонтуяа /-д даалгасугай.

ДАРГА А.ЗУРГААНЖИН

D:2022/Tushaal-A/.doc

421230008

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын
2023 оны 01 дүгээр сарын 02 өдрийн А/01
тоот тушаалын 1 дүгээр хавсралт

Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц,
орон тоо

| № | Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтэц | Орон тоо |
|---|---|---|
| 1 | Захиргаа, санхүү хөрөнгө оруулалтын нэгж | 5 |
| 2 | Сургалт, арга зүйн нэгж | 10 |
| | Нийт | 15 |

| № | Албан тушаал | Батлагдсан орон тоо |
|---|---|---|
| | **Захиргаа, санхүү, хөрөнгө оруулалтын нэгж** | |
| 1 | Архив, бичиг хэрэг | 1 |
| 2 | Нярав | 1 |
| 3 | Гэрээт үйлчлэгч | 1 |
| 4 | Гэрээт Жолооч | 1 |
| 5 | Харуул | 1 |
| | **Сургалт, арга зүйн нэгж** | |
| 6 | Дарга | 1 |
| 7 | Төсвийн мэргэжилтэн, нягтлан бодогч | 1 |
| 8 | Сургалтын бодлогын хэрэгжилт, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл, боловсролын баримт бичиг, шинжлэх ухаан, технологи, инноваци, мэргэжлийн боловсрол хариуцсан ахлах мэргэжилтэн | 1 |
| 9 | Сургуулийн өмнөх боловсролын сургалт, арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | 1 |
| 10 | Бага боловсролын сургалт арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | 1 |
| 11 | Гадаад хэлний боловсролын сургалт арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | 1 |

| | | |
|---|---|---|
| 12 | Байгалийн ухааны боловсролын сургалт арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн | 1 |
| 13 | Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн | 1 |
| 14 | Статистикийн мэдээлэл, цахим технологи, хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн | 1 |
| 15 | Боловсролын хяналтын улсын байцаагч | 1 |
| | Нийт орон тоо | 15 |